

## ДӨЧ ГОЛ-БАРУУН БИТҮҮГИЙН ГЕОМОРФОЛОГИЙН ТОГТОЦ

Я.Болд, Г.Чинбат

*Геологи, Минералогийн тэнхим*

Баруун битүүгийн алтны шороон орд нь Дөч голын эхний зүүн дээд цутгал болох Баруун битүүгийн хөндийд байрлана. Хөндийн нийт урт нь 5000 м, өргөн нь 80-300. Энэ хөндий нь дээд хэсэгтээ 1.8 км орчим урт, 60-80 м өргөн ба зүүн тал руу налуу байрлалтай задарсан хэлбэртэй, дунд хэсэгтээ жигд цүлхгэр өргөн болсон. Хөндлөн огтлол нь тэвш хэлбэртэй ба урт нь 1.6 км, өргөн нь 150-200 м, доод хэсэгтээ жигд цүлхийсэн зуйван, хөндлөн огтлол нь U хэлбэртэй ба урт нь 1.2 км, өргөн нь 200-300 м байна. Хөндий нь төгсгөлдөө хоёр талаасаа хошуурсан дэнжийн хурдсаар шахагдан нарийсч 60 м орчим болох ба цаашид задарч Дөч голын хөндий рүү дахин хошуурсан туугдас үүсгэж нийлнэ. Хөндийн налуугийн унал нь  $2.4^{\circ}$  ба ул чулууны зургаас ажиглахад 2 жижиг гольдролын зүй тогтол харагддаг. Баруун талын хөвөөг дагаж бүдэгхэн мөргөцөг маягийн дэнж, харин зүүн тал нь алсаас нилээд налуу хэлбэртэй задгайрч тогтсон байдаг.

Хоёр талын усан хагалбар нь баруун хойноос зүүн урагшлах тутам намсаж налуу болно. Хөндийн дээд эхээр Баруун битүүгийн цухуйц /1060-1160 м/, дунд хэсгээр хагарлын бүс дагаж доош суусан хөтөл маягийн конгломератын биет, доод хэсгээр Баруун битүүгийн цухуйцын үлдэгдэл / Баруун битүү толгой, Зүүн битүү толгой/ байдаг.

Хөндийн ул чулуу нь дээд хэсэгтээ элсэн чулуу, занарын үелэсэн зузаалаг, дунд хэсэгт шигтгээт боржин ба субинтрузив биет, доод хэсэгтээ риолит, андезитын долгиолог хэлбэртэй гадаргуу ермийн шугмын үр дүнгээр тогтоогдсон болно.

Баруун битүүгийн алтны шороон орд нь адил нэртэй хөндийн сэвсгэр хурдсанд агуулагдана. Хөндийг дөрөвдөгчийн сэвсгэр хурдас дүүргэх ба насны хувьд дээд дөрөвдөгч болон орчин үеийнх нь хуримтлагдсан хурдасны зузаан харьцангуй бага, хөндийн дунд доод хэсэгт 3.2-4.0 зузаантай байх ба Дөч гол руу нийлж буй хэсэгт 6-8 м, хөндийн дээд хэсэгт зөвхөн нарийн гуу орчимдоо 2.4-3.0 м хүрнэ.

Сэвсгэр хурдасны зүсэлтийн дараалалыг дээрээс доош үлгэрлэн харуулвал: хөрс ургамлын үе, делювиал-солифлюкцийн үйрмэг, элсэнцэр ба шавранцар, үйрмэг хайргатай-элсэнцэр, хагарал өгөршилд хүчтэй орсон элсжин, занар, шигтгээт боржингийн үе 0.8-1.6 м хүртэл хэлбэлзэлтэй тогтсон байна. Алттай давхарга нь 0.4-4.0 м хүртэл зузаантайгаар хагарал дагаж үүссэн гуу орчмын дагуу 30-80 м өргөнтэй тархсан байна. Аллювийн гаралтай хөндийд цутгасан жалгуудын делюви-аллювийн хурдсанд алтны цөөн тооны жижиг тэмдэгт үзэгдэх төдий илэрнэ.

Алт агуулсан сэвсгэр хурдас нь 0.2-1.6 м хүртэл сайрга, сайрганцар маш бага хэмжээгээр агуулсан хар хүрэн өнгийн шавар, 1.6-4.6 м хүртэл дунд зэрэг мөлгөржсөн хайрга, хайрганцар бүхий саарал өнгийн элс, элсэнцэр, 1.6-6.4 м хүртэл мөлгөржсөн хайрга, хайрганцар маш бага хэмжээгээр агуулсан саарал өнгийн шавранцар, шавранцарын дор ул чулууны 0.8-1.6 м өгөршсөн хэсэг тус тус байрлана. Хөндийн баруун талд дунд хэсгээр намхан /0.8-1.6 м/ чулуун дэнж тод ажиглагдах ба зүүн тал нь нилэнхүйдээ жигд задгай налуутай болсон байдаг. Энэ хөндийн алттай давхаргыг агуулсан хэсэг нь шууд ул чулууны дээрээ байрлах ба алт агуулсан давхаргыг хоёр хажуугаас нь шахаж өгсөн байрлалтай цайвар саарал өнгийн шавранцарын үе ул чулууны дээр байрлаж буй нь хөндлөн зүсэлтүүдэд тод ажиглагдана.

Баруун битүүгийн хөндийн хурдас нь аллюви-делювийн гаралтай хуримтлал юм. Тус орд нь алтны нэг давхаргатай ба хучаас хурдасны зузаан нь 1.2-3.2 м, алттай давхаргын зузаан нь 1.2-3.2 м алтны дундаж агуулга  $513 \text{ кг/м}^3$ . Алт нь цэвэр алтанд шилжүүлснээр /98.87 кг/. Алттай давхарга нь 206-р шугам дээр тасалдаж хоёр хэсэгт хуваагдах ба дээд хэсгийн алттай давхаргын урт 1478 м, өргөн нь 35-72 м ба хучаас хурдасны зузаан 1.48 м, алттай давхаргын зузаан 2.22 м, алтны дундаж агуулга  $470 \text{ мг/м}^3$ , алт нь цэвэр алтанд шилжүүлснээр 47.53 кг байлаа.

РЕЗЮМЕ

Геоморфологическое строение района  
Дөч гол- Баруун битүү

В результате полевых исследований и пределах района уточнены геоморфологическое строение и закономерности размещения россыпных месторождения золота.

АШИГЛАСАН БҮТЭЭЛҮҮД

1. Хээрийн судалгааны анхдагч материалууд